



**МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: (976-51) 26-33-33, E-mail: info@med.gov.mn,
http://www.med.gov.mn

2014.4.22 № 8/794


танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНД**

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд тус яамнаас ирүүлж байх албан мэдээ, мэдээллийг хуваарь, мэдээллийн төрлийн дагуу 2014 оны 1 дүгээр улирлын байдлаар гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт бүгд ⁵..... хуудас.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Р БААСАНЖАВ



**ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНААС ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД
ТАНИЛЦУУЛАХ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ**

/2014 оны 1-р улирлын байдлаар/

Эдийн засгийн хөгжлийн яамны
2014 оны 4 дүгээр сарын 28 өдрийн
8/2014 тоот албан бичгийн Хавсралт

Мэдээллийн төрөл		Мэдээ, мэдээллийн талаарх танилцуулга
Зохион байгуулсан зарим ажлууд	Яамны хэмжээнд зохион байгуулсан ажлын товч танилцуулга	<p>"Нэг маягийн загвар зураг"-ийн талаар мэдээлэл бэлтгэж, сэтгүүлчид болон холбогдох хүмүүст 2014 оны 1 дүгээр сарын 13-нд бүтээн байгуулалтын цагаар танилцуулав.</p> <p>-ЭЗХЯ, ССАЖЯ, БШУЯ-ны хамтарсан ажлын хэсэг УБ-Өвөрхангай-Булган-Сэлэнгэ-Эрдэнэт-Дархан-УБ маршрутын дагуу Уул уурхайн чиглэлийн 7 үйлдвэр, 3 хөнгөн үйлдвэр, соёл, спорт, шашны чиглэлийн 10 объект, боловсролын салбарын 2 объект нийт 22 бүтээн байгуулалтын ажилтай газар дээр нь очиж танилцан, практик дадлага эзэмших сургалтыг 2014 оны 02 дугаар сарын 23-наас 03 дугаар сарын 03-ны хооронд зохион байгуулав. "Эрдэнэт хивс" ХК, "Дархан нэхий" ХК-уудын удирдлагатай уулзан суманд туршилтын жишиг УТП байгуулахад хамтран ажиглах талаар урьдчилан ярилцан тохиролцож, бичгээр саналгаа уламжлахаар тохиролцов.</p> <p>-ЭЗХЯ, БХБЯ, УХААДЯ, ХЯ-ны төлөөлөл бүхий ажлын хэсэг, Архангай аймгийн Ажлын хэсэг, Эрдэнэмандал сумын ажлын хэсэг хамтран УТП байгуулах боломжит байршлыг сонгон, хөгжүүлэх боломжтой үйлдвэрийн жагсаалт, дэд бүтцийг шийдэх боломжийн талаар судалж, саналаа удирдлагад танилцуулахаар болгов. Булган аймгийн орон нутгийн удирдлагатай уулзан Хутаг-Өндөр суманд туршилтын УТП байгуулахаар тохиролцов. Эхний ээлжинд Архангай аймгийн Эрдэнэмандал, Булган аймгийн Хутаг-Өндөр, Завхан аймгийн Баянхайрхан суманд УТП байгуулах ТЭЗҮ-ийг гүйцэтгүүлэхээр ТНБД-ын тушаал гаргуулахаар ажиглаж байна.</p> <p>-Яамны "Эрүүл амьдрал" анхдугаар спортын наадмыг амжилттай зохион байгуулав.</p> <p>-Сар шинийн баярыг тохиолдуулан яамны 350 гаруй ахмадад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулав.</p>
Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлууд		<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2016-2017 оны төсөөлөл, 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тодотголын төсөл, 3. Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2016-2017 оны хөгжлийн төсөөллийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн тооцоолол,

	<p>4. Худалдааны тухай хуулийн төсөл, 5. Азийн хөгжлийн Банкны шугамаар хэрэгжүүлэх "Хүнс, тэжээл, нийгмийн халгамжийн төсөл-Нэмэлт санхүүжилт" зээлийн хэлэлцээр, 6. Азийн хөгжлийн Банкны шугамаар хэрэгжүүлэх "Төлбөрийн системийн шинэчлэл төсөл"-ийн зээлийн хэлэлцээр, 7. Азийн хөгжлийн Банкны шугамаар хэрэгжүүлэх "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн зээлийн хэлэлцээр, 8. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Полыш Улсын Засгийн газар хоорондын "нөхцөлт" зээлийн хэлэлцээр, 9. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох тухай хуулийн төсөл, 10. "Баруун бүсийн оношлогоо, эмчилгээний төвийг бэхжүүлэх" төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг авах тухай Монгол Улс, Бельгийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, 11. БНХАУ-ын Засгийн газрын зээлийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх "Цахим эрүүл мэнд" төслийн хэлэлцээр, 12. Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийн концессын гэрээний төсөлд яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газраар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд 2014 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Засгийн газрын 69 дугаар тогтоолоор уг концессын гэрээг "Кью Эс Си" ХХК-тай байгуулах эрхийг ЭЭХ-ийн сайдад олгосон.</p>
<p>2014 оны 1 дүгээр улиралд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудлууд</p>	<p>1.Боомтын хөгжлийн загвар болон түүнд хамаарах давтан хэрэглэгдэх зургийн жагсаалтыг Засгийн газрын 2014 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, Засгийн газрын 2014 оны 8 дугаар тогтоолоор батлуулав. 2.Нэг дээвэр доор байрлан үйл ажиллагаа явуулах байгууллагуудын нэг маягийн зураг төсөл боловсруулж ажлын хэсэг байгуулах тухай саналыг Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2014 оны 19 дүгээр тушаалаар батлуулав. 3.Нүүрс хийжүүлэх үйлдвэр байгуулах төслийн нэгжийн 2014 онд шаардагдах санхүүжилтийг олгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв. 4.Засгийн газрын 2013 оны 46 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2014 оны 96 дугаар тогтоолоор батлуулав. 5. Дэлхийн худалдааны байгууллагад хянуулах Монгол Улсын худалдааны бодлогын тайланг боловсруулж 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлэв. 6. Япон Улсын Засгийн газраас олгох хөнгөлөгттэй зээлийн шугамаар хэрэгжүүлэх дулааны IV цахилгаан станцын үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх төслийн зээлийн хэлэлцээрийг 2014</p>

	<p>оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.</p> <p>7. Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/ хооронд байгуулах "Инженер, технологийн дээд боловсрол төслийн зээлийн хэлэлцээр"-ийн төслийг 2014 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.</p> <p>8. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулах "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр-Хоёрдугаар төслийн зээлийн хэлэлцээр"-т гарын үсэг зурах бүрэн эрх авах тухай асуудлыг 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.</p> <p>9. Монгол Улсын Засгийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/ хооронд байгуулах "Инженер, технологийн дээд боловсрол" төслийн зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах бүрэн эрх авах тухай асуудлыг 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.</p>
<p>2014 онд УИХ-аар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа хууль, шийдвэрийн төслүүд</p>	<p>1.Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон 2016-2017 оны хөгжлийн төсөөллийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн тооцоог хийх, дунд хугацааны зорилтуудыг тодорхойлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, улмаар УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2016-2017 оны төсөөллийг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>3.Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг боловсруулж, 2015 төсвийн төсөлд нэгтгэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>4.“Эдийн засгийн шинэчлэлийн багц хууль-1-2”-ыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>5.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>6.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тодотголыг хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх;</p> <p>7.Монгол Улсын 2014-2018 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл;</p> <p>8. Хуралдааны тухай хуулийн төсөл;</p> <p>9. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Полыш Улсын Засгийн газар хоорондын “нөхцөлт” зээлийн хэлэлцээр;</p> <p>10. Азийн хөгжлийн банкны шугамаар хэрэгжүүлэх “Хүнс, тэжээл, нийгмийн халамжийн төсөл-Нэмэлт санхүүжилт” зээлийн хэлэлцээр;</p> <p>11. Азийн хөгжлийн банкны шугамаар хэрэгжүүлэх “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээр;</p> <p>12. Азийн хөгжлийн банкны шугамаар хэрэгжүүлэх “Улаанбаатар хотын гэр хорооллыг</p>

	<p>хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн эзэлийн хэлэлцээр; 13. "Баруун бүсийн оношлогоо, эмчилгээний төвийг бэхжүүлэх" төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг авах тухай Монгол Улс, Бельгийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр; 14. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орох тухай хуулийн төсөл; 15. Концессын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.</p>
<p>Концессын тухай хуулийн хэрэгжилт</p>	<ol style="list-style-type: none"> 1. "Туул Сонгино" усны нөөцийн цогцолбор төслийг "Морытимпекс" ХХК-тай байгуулахыг Засгийн газрын 2013 оны 403 дугаар тогтоолоор Эдийн засгийн хөгжлийн сайдад зөвшөөрсөний дагуу гэрээ байгуулахад бэлэн болсон. 2. "Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд" чиглэлийн хурдны авто замын төслийн концессын гэрээ байгуулах зөвшөөрлийг Засгийн газрын 2013 оны 399 дүгээр тогтоолоор Эдийн засгийн хөгжлийн сайдад олгосон ба 2014 оны 03-р сарын 09-ны өдөр "Чингис гэнд дөвөлөмтөнт групп-Шинэ хөгжлийн зам" ХХК-тай гэрээг байгуулсан. 3. "Нисэх онгоцны буудал болон нийслэлийг холбосон авто зам" төслийн концессын гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг ТНБД-ын 2014 оны 10 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна. 4. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто зам төслийн концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт Нарийн Сухайтаас-Шивээхүрэн боомт хүртэл авто зам барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих ажлын хэсгийг ЭЗХҮ-ны 2012 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 54 тоот тушаалаар байгуулан ажиллаж байна. 5. Монгол улсын ЗТ-ын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн концессийн зүйлийн жагсаалт"-д тусгагдсан "Хүний хөгжлийн төв" цогцолбор байгуулах концессын төслийн гэрээний хэлэлцээр хийх ажлын хэсгийг ЭЗХ-ийн Сайдын 22 тоот тушаалаар 2014 оны 03 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. 6. ТНБД-ын 2013 оны 9-р сарын 20-ны өдрийн 217 тоот тушаалаар байгуулагдсан "Туул усан сан барих төсөл"-ийн концесс олгох уралдаант шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах, уралдаант шалгаруулалтыг зарлах, түүнийг зохион байгуулж дүгнэх үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж байна. 7. "Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг уул уурхай металлургийн цогцолбор болгон өөрчлөх төсөл"-ийн концессын гэрээ байгуулах ажлын хэсэг дарханы төмөрлөгийн үйлдвэр болон төмрийн ордын үйл ажиллагаатай танилцсан. Концессын гэрээний төсөлд яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газраар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд ЭЗХ-ийн сайдад гэрээ байгуулах эрхийг олгоод байна. 8. 2014 оны 3-р сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Авто замын олон улсын үзэсгэлэн, хуралдаан"-д оролцож эдгээр төслүүдийн талаар танилцуулав. 9. Сингапурын Хөгжлийн Агентлаг(SCE)-тай хамтран 2014 оны 1-р сарын 22-24-ний өдрүүдэд Сингапур улсын хамтын ажиллагааны нийгэмлэг болон КРМГ зөвлөх компанитай хамтран Төр-хувийн хэвшлийн ойлголтын талаарх сургалтыг бусад яам, холбогдох байгууллагууд, Архангай аймгийн эдийн засгийн хөгжлийн газрын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. 10. 2014 оны 2-р сарын 19-ний өдөр Азийн хөгжлийн банктай хамтран "Төр-хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлага"-ыг боловсруулж, танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан. 11. 2014 оны 02-р сарын 21-ний өдөр Азийн хөгжлийн банктай хамтран "Төр-хувийн хэвшлийн түншлэлийн

	<p>зөвлөлдөх үүлээлт"-ыг манай улсад суугаа Элчин сайдын яамд, Азийн Хөгжлийн Банк, Нэгдсэн Үндэсний Байгууллага, Дэлхийн Банк, Япон Уулсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Олон улсын санхүүгийн байгууллага, Европын сэргээн босголт хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудын төлөөлөгчдийг оролцуулан зохион байгуулсан.</p>
<p>Чөлөөт бүсийн тухай хуулийн хэрэгжилт</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хуулийн дагуу чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албад байгуулагдсан. 2. "Алтанбулаг" Худалдааны чөлөөт бүс, "Замын-Үүд" Худалдааны чөлөөт бүсэд Мэргэжлийн хяналтын алба байгуулагдсан. 2. Чөлөөт бүсүүдийн газрын хэмжээ, хиллийн заагийг УИХ-ын тогтоолоор баталгаажуулсан. 3. Чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчдын зөвлөл байгуулагдсан. 4. Улсын төсвийн болон БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө оруулалт, хувийн хөрөнгө оруулалт хийгдэж байна. Одоогийн байдлаар улсын төсвөөс 28.8 тэрбум төгрөг, хувийн хэвшлээс 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. "Замын-Үүд" Худалдааны чөлөөт бүсэд "Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 31.3 сая ам долларын хөрөнгө оруулалт хийгдэж дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. 5. "Алтанбулаг" Худалдааны чөлөөт бүсэд дотоодын цэргийн, "Замын-Үүд" Худалдааны чөлөөт бүсэд хиллийн цэргийн харуул хамгаалалтын алба ажиллаж байна. 6. "Алтанбулаг" Худалдааны чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба газрын төлбөрийн орлогын тодорхой хэсгийг Засгийн газрын тогтоолын дагуу орон нутгийн төсөвт оруулж байна. 7. Чөлөөт бүс дэх үйл ажиллагааны тусгай дэглэмийн дагуу Чөлөөт бүсэд Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалаггүй хүн оршин суух, зорчих журам, шалган нэвтрүүлэх хялбарчилсан журам, чөлөөт бүсэд виз олгох журам, чөлөөт бүсэд гаалийн хяналт тавих журам, чөлөөт бүсэд аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх журмууд батлагдан мөрдөгдөж байна. 8. Одоогийн байдлаар чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахаар 86 аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлснээс 3 аж ахуйн нэгж хөрөнгө оруулалт хийсэн.

-----О О О-----